



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Самбарт зурсан 8 дугуй дүрсийг 1: 3 харьцаатай цагаан ба хөх өнгөөр будав.



1 цагаан дугуй тутамд, 3 хөх дугуй будсан байна.

1 Дугуй дүрсүүдийг 1: 2 харьцаатай хөх ба улаан өнгөөр будаарай.



Нийт хэдэн дугуй дүрс байна вэ? _____

Хэдэн хөх дугуй будсан бэ? _____

Хэдэн улаан дугуйг будсан бэ? _____

2 Дараах тэгш өнцөгт дүрсүүдийн талбайг 1: 2 харьцаатай хувааж, будаарай.

Хэдэн тэнцүү хэсэгт хэрхэн хуваах вэ?




3 Зүй тогтлыг ажиглаад, үргэлжлүүлэн дүрсийг зураарай.



3 Номын дэлгүүр 1 ном худалдан авахад ном тус бүрд 2 бал бэлгэнд өгч байв. Хүү 3 ном худалдан авсан бол хэдэн бал бэлгэнд вах вэ?

ном
 бал



3 Нэг аяга цайнд 2 ширхэг ёотон хийдэг бол, энэ харьцаагаар 5 аяга цайнд хэдэн ёотон хэрэгтэй вэ?



Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4
Өөрийн үнэлгээ				



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Малчин 100 бог малтай. Хонь ба ямааны тоо $2 : 3$ харьцаатай бол малчин хэдэн хонь, хэдэн ямаатай вэ?

Зураглал

Төлөвлөгөө

Бодолт

Шалгах

хонь }
 ямаа } 100

1) Нийт хэдэн тэнцүү хэсэг вэ?

$2 + 3 = 5$

$2 : 3$

2) 1хэсэгт хэдэн бог ногдох вэ?

$100 \div 5 = 20$

$(2 + 3) \times 20 =$

3) Хэдэн хоньтой вэ?

$2 \times 20 = 40$


$40 + 60 = 100$

4) Хэдэн ямаатай вэ?


$3 \times 20 = 60$




1) Биеийн тамирын зааланд 10 бөмбөг байв. Сагсны ба гар бөмбөгний тоо $3 : 2$ харьцаатай бол зааланд хэдэн сагсны бөмбөг, хэдэн гар бөмбөг байсныг тооцоолоорой.



2) Дэлгүүр лууван, манжин нийлээд 30 шуудайг худалдав. Дэлгүүр луувангаас 2 дахин их манжин худалдсан бол хэдэн шуудай лууван, хэдэн шуудай манжин худалдсан бэ?



3) Аав, хүүгийн насны харьцаа $2:1$ ба аав нь 50 настай бол хүү нь хэдэн настай вэ?



3) Дээрх бодлоготой төсөөтэй зохиож бичээрэй.

Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4
Өөрийн үнэлгээ				



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Пропорцийн мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олж шалгаарай.

1 а. $8 : A = 16 : 2$

б. $10 : T = 20 : 4$

2 а. $A : 2 = 6 : 2$

б. $B : 5 = 20 : 2$

3 а. $15 : 3 = C : 2$

б. $50 : 5 = K : 2$

4 а. $45 : 3 = 60 : X$

б. $180 : 6 = 90 : Y$

Тэнцүү харьцаа зохиож шалгаарай.

5 а. $180 : 6 = _ : _$

б. $180 : 6 = _ : _$

в. $_ : _ = 60 : 5$

г. $_ : _ = 75 : 5$

Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4	5
Өөрийн үнэлгээ	😊	😊	😊	😊	😊




Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Пропорцийн мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олж шалгаарай.

1 а. $12 : A = 24 : 4$



б. $81 : T = 27 : 3$



2 Тэнцүү харьцаа зохиож шалгаарай.


а. $20 : 4 = _ : _$




б. $_ : _ = 36 : 9$




3 Сургуулийн хашаанд 180 мод тарьж ургуулсан. Навчит мод болон шилмүүст модны тоо 4:5 харьцаатай байв. Сургуулийн хашаанд навчит ба шилмүүст мод тус бүр хэдэн ширхэг ургаж байгаа вэ?



4 Ах, дүүгийн өндрийн харьцаа 2:1 ба ах нь 150 см өндөртэй бол дүүгийн өндөр хэд вэ?



5 Хэрчмийг 3 дахин богиносгож зураарай. Хоёр хэрчмийн харьцаа $_ : _$



6 Дугуй дүрсүүдийг 1: 2 харьцаатай хөх ба улаан өнгөөр будаарай.



Дууссан:сарөдөр



Даалгавар	1	2	3	4	5	6
Өөрийн үнэлгээ	😊	😊	😊	😊	😊	😊